

**БУЛГАН АЙМГИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
<i>Нэг.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ</i>							
<i>1.1.“Алсын хараа 2050” бодлогын баримт тусгагдсан зорилт, арга хэмжээ</i>							
1.1.1	Соёлын үнэт зүйлсийг судлан соёлын орчин орон зай брэндийг бий болгох чиглэлээр дэмжлэг үзүүлэх	ОНТ 73.2 сая төгрөг	Соёлын брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг эдийн засгийн эргэлтэнд оруулсан байх	-	Соёлын нөөц орон зайд тулгуурласан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авсан байх	"Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлцгээе" уриан дор зохион байгуулагдсан "VISIT BULGAN-2023" аялал жуулчлалын форумд оролцож Булган аймгийн түүх, соёлын дурсгалт газруудын онцлог мэдээллийг хүргэж Соёлын аялал жуулчлалын маршрутыг танилцууллаа. Сэлэнгэ сумын 3-р багийн нутаг дахь соёлын дурсгалт газрыг түшиглэн Фантастик продакшины ээлжит уран бүтээл болох ХҮННҮ ГҮРЭН 3 бүлэг 30 ангит киноны Луут хотын Фалгионыг барьж байгуулах эхний төлөвлөлтийг хамтран гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд 10 га газар төлөвлөгдөж байгаа бөгөөд кино зураг авалт хийгдсэнээр аялал жуулчлалын томоохон урсгалыг бий болгох бүрэн боломжтой юм. Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн "Монгол Өв" соёл нэвтрүүлгийн редацитай хамтран Орхон, Булган, Хутаг-Өндөр сумын онцлог, соёлыг харуулсан нэвтрүүлэг бэлтгэж тус нэвтрүүлэгт 5 өвлөн уламжлагч оролцож орон нутгийн онцлог, өв, түүх соёлын дурсгалт газрын талаар мэдээллийг хүргэлээ. Мөн тус телевизтэй хамтран Рашаант сумын Хөгнө хан уул, Элсэн тасархай, Их бага хийдийн туурь, Хадат хошуу зэрэг газруудаар аяллын маршрут гаргаж хүүхдийн танин мэдэхүйн "Том ахын аялал" нэвтрүүлэг бэлтгэн тус нэвтрүүлэгт Рашаант, Булган сумын ЕБС-ийн сурагчид оролцлоо. "Монголын баялаг-330" төсөл хөтөлбөрийн хүрээнд "Монгол өв соёл" ХХК-тай орон нутгийн төсвийн 73.2 сая	100%

						төгрөгөөр гэрээ байгуулан сум тус бүрд 35 минутын хугацаатай 16 контент бэлтгэн МҮОНТ-ээр олон нийтэд хүргэлээ. Тус ажлаар Булган аймгийн 16 сумын нутаг дэвсгэрт орших байгалийн цогцолбор газар 48, түүхэн дурсгалт газар-32, түүх соёлын үл хөдлөх дурсгал-80, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч иргэн-32 хамрууллаа. Дээрх ажлууд нь соёлын аялал жуулчлалыг татах, орон нутгийн онцлог, өв соёлоо сурталчлах, ирээдүй хойч үедээ дүрсжүүлэн өвлүүлэн үлдээсэн ач холбогдолтой ажил боллоо.	
1.2.МУ-ын таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.2.1	Аймгийн нутаг дэвсгэрт орших Соёлын биет өвийн дурсгалыг бүртгэлжүүлэх	-	Шинээр бүртгэгдсэн өвийн тоо,	2022 онд 513 дурсгалт газрын 2982 дурсгал	Жилд: Шинээр 16-с доошгүй өвийг бүртгэлд хамруулах	Рашаант сумын 2-р багийн нутагт орших Хар чулуут уулын энгэрийн “Хиргэсүүр”, 1-р багийн нутагт орших Гурван цохио уулын “Тамганы үсэг”, Рашаатын амны “Нанж вандан” бичээс зэрэг 3 соёлын биет өвийн дурсгалыг бүртгэлжүүлэх саналыг хүлээн бүртгэлд хамруулсан.	30%
1.2.2	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулагчдын шавь сургалтаар өвийг уламжлуулах талаар дэмжиж /Уламжлалт арга ухаан, гар урлалын/ төрлөөр дугуйлан хичээллүүлэх	ОНТ -1.0 сая төгрөг УТ-1.5 сая төгрөг	Үйл ажиллагаа, сургалтын тоо өвлөн суралцагчдын тоо	3 иргэнийг алдаршуулсан.	10-с доошгүй төрөл зүйлээр өвийг уламжлуулах, 100 хүнийг сургаж өвлүүлж 6-гаас багагүй үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор гар урлал, уламжлалт арга ухаан, уламжлалт баяр наадам, язгуур урлаг, эх хэл аман уламжлалын 7 төрлөөр сургалт зохион байгуулж 466 хүүхэд, 54 насанд хүрэгчийг хамруулан өвийг өвлөн уламжлуулж байна. Мөн Булган хангай өв соёлын наадам, Манлайн баясгалан өв соёлын уралдаан, Монгол наадам тайлбарт тоглолт, Булган сумын Өвлөн уламжлагчдын чуулган, Өвлөн уламжлагчдын тайлбарт тоглолт, Бүтээлч булганчууд үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгуулан Аймгийн шилдэг өвлөн уламжлагчийг шалгаруулж 1.0 төгрөгөөр урамшууллаа.	100%
1.2.3	Соёлын биет өвийг таниулах аялал, Соёлын биет бус өвийн сургалт нөлөөллийн үйл ажиллагаа явуулах	-	Үйл ажиллагааны тайлан, хамрагдсан хүүхдийн тоо	6 сумын 844 сурагч хамрагдсан.	1. 16 сум 1 тосгоны Соёлын төв СӨБ-ын хүүхдүүд, ЕБС-ийн 6-9 ангийн сурагчдад соёлын биет өвийн аялал зохион байгуулна. 2. 16 сум 1 тосгоны Соёлын төв ЕБС-	Соёлын биет өвийг таниулах аялалд 7 сумын 1126 хүүхэд (Музей-506, Сайхан-70, Баян-Агт-18, Бугат-100, Гурванбулаг-134, Орхон-185, Булган-98, Рашаант-15), Соёлын биет бус өвийн сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд 6 сумын 1393 (Хутаг-Өндөр-200, Сайхан-70, Баян-Агт-220, Тэшиг-80, Бүрэгхангай-20, Булган-803) хүүхдийг тус тус хамруулж соёлын биет болон соёлын биет бус өвийн	70%

					ийн 6-9 ангийн сурагчдад соёлын биет бус өвийн сургалтыг зохион байгуулна. 3. Аймгийн музей МСҮТ-ийн оюутнууд, ЕБС-ийн 10-11-р ангийн сурагчдад соёлын биет болон биет бус өвийн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж хүүхдүүдийн ойлголт мэдлэг сайжирсан байна. Чиглэл тус бүрээр 1-ээс доошгүй үйл ажиллагаа явуулсан байна.	талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 шторк, Өвлөн уламжлагчид болон өвийг сурталчлах хүрээнд 5 цуврал контентийг бэлтгэн олон нийтэд түгээж 9713 хүнд хүргэсэн. Виртуал музейгээр Шивээт улааны цогцолбор, Цогтын цагаан байшин, Чин толгойн балгас, Өвгөн хийд, Далхбандида, гэсэн 6 газрыг 600 гаруй хүүхдэд сурталчлан таниулж сургалт нөлөөллийн ажлыг зохион байгууллаа.	
1.2.4	Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулж, зэрэглэл тогтооно.	-	Бүртгэгдсэн баримтат, өвийн тоо	Иргэдэд хадгалагдаж байгаа баримтат өвийн бүртгэл байхгүй.	Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа 5-с доошгүй баримтат өвийг бүртгэсэн байна.	Баян-Агт, Хишиг-Өндөр, Хангал, Сэлэнгэ, Бүрэгхангай, Сайхан, Дашинчилэн Бугат, Булган, Гурванбулаг сумын иргэдийн гар дээр болон сүм хийдэд хадгалагдаж байсан 50 баримтат өвийг улсын бүртгэл мэдээллийн санд бүртгүүлэхээр санал хүргүүлсэн. Мөн аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа 55 өвийг Соёлын яаманд хүргүүлж бүртгэлд хамруулсан.	100%
1.2.5	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэхэд хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллана.	-	Хамтран ажилласан тоо	Хамтран ажиллаж байгаагүй	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг гараагүй байх.	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор Булган аймгийн Цагдаагийн газартай хамтран ажиллах 12 арга хэмжээ бүхий төлөвлөгөө баталж 83.3 хувьтай гүйцэтгэлээ. Мөн Булган аймаг дахь Цагдаагийн газартай хамтран “Сүм хийд” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж аюулгүй байдлын заавар зөвлөмж болон баримтат өвийн бүртгэлийн маягт бөглөх аргачлалын талаар сургалт зохион байгууллаа. Соёлын өвийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх богино хэмжээний 5 шторк бэлтгэн олон нийтэд	100%

						түгээж 557 хүн үзэж сонирхсон. Соёлын өвийн гэмт хэрэг гараагүй байна.	
1.2.6	Улс, аймгийн хамгаалалтад байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулна.	-	Гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн тоо	Улсын хамгаалалтын жагсаалтад 12, аймгийн хамгаалалтын жагсаалтад 41 дурсгал орсоноос 32 дурсгал нь сайн дурын харуултай байгаа	Улс, аймгийн хамгаалалтад байгаа нийт түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалуулах гэрээг байгуулсан байна.	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Улс, аймгийн хамгаалалттай 53 дурсгалаас улсын 9 дурсгал, аймгийн хамгаалалттай 29 нийт 38 дурсгалыг хамгаалуулах гурвалсан гэрээг байгуулан ажиллаж байна. Хутаг-Өндөр суманд байрлах Төлбөрийн голын чулуун зэвсгийн суурин газар доор байрлалтай давхарга учир иргэнд хариуцуулах боломжгүй.	70%
1.2.7	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтад бүртгэгдсэн өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулахад дэмжлэг үзүүлэх	ОНТ	Эрүүл мэндийн Үзлэгт хамруулсан хүний тоо	Булган аймгаас 1 өвлөн уламжлагч байна.	Эрүүл мэндийн анхан шатны үзлэгт хамруулахад дэмжлэг үзүүлсэн байна.	Дашинчилэн сумын өвлөн уламжлагч Ц.Дондоог Улаанбаатар хотод эрүүл мэндийн анхан шатны үзлэгт хамруулсан. Мөн Цэргийн төв эмнэлэг Дашинчилэн суманд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах үед эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан.	100%
1.2.8	Соёлын биет бус өвийн бүсчилсэн судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх	УТ, ОНТ	Дэмжлэг үзүүлсэн эсэх	16 сум 1 тосгоны өвлөн уламжлагч хамрагдана	Бүсчилсэн судалгааны ажилд дэмжлэг үзүүлсэн байх	Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Булган, Сайхан, Баян-Агт, Орхон зэрэг 9 сумын 30 өвлөн уламжлагчийг Соёлын биет бус өвийн бүсчилсэн судалгааны ажилд хамруулж дэмжлэг үзүүлсэн.	100%
1.2.9	Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичиг сурвалжлан олж бүртгэх, сурталчлах ажлыг зохион байгуулах	-	16-аас доошгүй угийн бичгийг сурвалжлан олох	Бүртгэл хийгдэж байгаагүй.	Бүртгэн баримтжуулах ажлыг зохион байгуулсан байна.	Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичиг сурвалжлан олж бүртгэх, сурталчлах ажлын хүрээнд Хишиг-Өндөр, Гурванбулаг, Орхон сумаас 5 угийн бичгийг сурвалжлан олж бүртгэн 2 удаагийн сургалт зохион байгуулж 418 хүн хамрагдсанаас 40 гаруй өрх нь 5-аас дээш үеэр угийн бичгийн зураглалаа гаргасан байна	50%
1.2.10	Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл зэрэг давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгааны улмаас соёлын өвд учирсан хохирлыг бууруулах, авран хамгаалах, урьдчилан сэргийлэх	ОНТ-3.5 сая төгрөг	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо	Соёлын биет 2 өвийн дурсгалын саналыг явуулсан.	Дэмжлэг үзүүлсэн байна.	Тус арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ сумын нутагт Авто замын дэргэд байрлах Түүх соёлын 2 дурсгалыг хашиж хамгаалан, Баян-Агт сумын нутагт байрлах Халтарын буган чулуун хөшөө, Цагаан оломны буган чулуун хөшөө дурсгалын хашаа, Булган сумын нутагт орших Баатруудын хөшөө дурсгалыг сэргээн засварлаж, Дашинчилэн суманд байрлах Цогтын цагаан байшингийн гэрэлт хөшөөний хэвийг авч нийт 6 дурсгалыг авран хамгаалах арга хэмжээнд хамруулаад байна. Баруун	100%

	арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх					замын байлдааны штаб музейн 485 сая төгрөгийн их засварын зураг төсвийг аймгийн музей бүрэн хийж дууслаа. Үүнд сан хөмрөг, үзмэрийн танхим өрөө тасалгаанд агааржуулалтын хоолой хийхээр төлөвлөсөн. Соёлын яамны хөрөнгө оруулалтаар Төв музей болон, Баруун замын байлдааны штаб музейд 41,9 төгрөгийн дотор, гадна хяналтын камер, хөдөлгөөн мэдрэгч, ус чийг мэдрэгч зэрэг иж бүрэн дохиолол хамгаалалтын системийг суурилуулав.	
1.2.11	Соёлын биет өвийг улсын хамгаалалтын болон хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах	-	Нэр дэвшүүлсэн соёлын биет өвийн тоо	Нэр дэвшүүлж байгаагүй	Саналыг боловсруулж нэр дэвшүүлсэн байна.	Түшээт Хан Дашнямын хэт хутга, Ардын Хатанбаатар С. Магсаржавын Хантааз, Намхай аваргын хөөрөг, Солир зэргийг үнэт дурсгалт зүйлд нэр дэвшүүлэхээр саналыг Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлсэн. Мөн Хангал сумын Хялганат тосгоны нутаг дэвсгэрт байрлах Алтан уулын Хүннүгийн бүлэг оршуулгын дурсгалыг Аймгийн хамгаалалтад авах талаарх саналыг боловсруулж Хялганат тосгоны захирагчийн албанд хүргүүлсэн.	100%
1.2.12	Соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачлагатай ажилласан иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг урамшуулах, алдаршуулах арга хэмжээг зохион байгуулах	ОНТ-4.5 сая төгрөг	Урамшуулж алдаршуулсан иргэн, ААН байгууллагын тоо	2 иргэнийг алдаршуулсан	Иргэн, ААН байгууллагыг тодруулж урамшуулах, алдаршуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.	Соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай ажилласан 9 иргэнийг 3.5 сая төгрөгийн үнэ бүхий зүйл, 4 иргэний гэр бүлийг орон нутгийн үзвэр үйлчилгээг үнэгүй үзэх эрхээр урамшуулсан. /Музей-100.000, Бүрэхангай-400.000, Баян-Агт-600.000, Бугат-300.000, Гурванбулаг-1.800.000, Могод-100.000, Хангал-150.000/ Соёлын биет бус өвийг өвлөн уламжилж сурталчилан түгээн дэлгэрүүлж, хадгалж хамгаалах чиглэлээр идэвхтэй ажиллаж буй 5 иргэний талаар контент бэлтгэн цахимд байршуулж, 1 өвлөн уламжлагчид 1.0 төгрөгийн урамшуулал олголоо.	100%
1.2.13	“Нүүдэлчин Монгол” Олон Улсын фестивальд оролцох	УТ-22.8 сая төгрөг ОНТ-14.4 сая төгрөг	Наадмыг зохион байгуулсан тайлан, оролцогчдын тоо	2022 онд 41 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.	Фестивалд оролцсон байна.	Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалт болон ЮНЕСКО-ийн яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн Монголчууд бидний оршихуй болсон үнэт соёлын биет бус өвүүдээ өвлөн уламжлуулах, сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2023 оны 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн Тайж	100%

						хайрхны бэлд зохион байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд Булган аймгийн төлөөлөл 3 дахь удаагаа 42 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 7 ай савын 362 өвийн төрлөөс эх хэл аман уламжлал, ардын язгуур урлаг, байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, уламжлалт арга ухаан, уламжлалт гар урлал зэрэг 5 ай савд багтах 19 өвийн төрлийг түгээн дэлгэрүүлж үзүүлбэр, тоглолт, үзэсгэлэн, брэнд бүтээгдэхүүн боловсруулах зэргээр орон нутгийн онцлог айраг, адууны өв соёлтой холбогдох зан үйл, соёл уламжлалаа сурталчлан таниулсан.	
1.2.14	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын Улсын тооллогыг Хутаг-Өндөр, Хангал, Орхон, Тэшиг сумд дахин зохион байгуулах Сэлэнгэ, Могод, Рашаант, Гурванбулаг сумд бүртгэлд хамрагдаагүй үлдсэн дурсгалыг тооллогод хамруулах	ОНТ	Тооллогод хамрагдсан газар дурсгалын тоо	12 сум тооллогод хамрагдсан	Тооллогын үйл ажиллагааг зохион байгуулж тайланг хүргүүлсэн байна.	2022 оны тооллогын үйл ажиллагаанд хамрагдаагүй үл хөдлөх дурсгалын тооллогыг дахин зохион байгуулах чиглэлийг Сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн. Хангал сум тооллого дахин зохион байгуулж, Сэлэнгэ сум бүртгэлд хамрагдаагүй 3 дурсгалаас 1 дурсгалыг тооллогод хамруулсан.	30%
1.2.15	Соёлын биет бус өвийн тооллого зохион байгуулж бүртгэлийн шинэчлэх	-	Тооллогод хамрагдсан өвлөн уламжлагчийн тоо	16 сум 1 тосгоны 190 өвлөн уламжлагч бүртгэлтэй	Тооллогын ажлыг зохион байгуулж бүртгэлийг шинэчилсэн байна.	2022 оны жилийн эцсийн байдлаар 190 өвлөн уламжлагч бүртгэл мэдээлийн санд бүртгэлтэй байсан. Соёлын биет бус өвийн тооллого зохион байгуулж бүртгэлийг шинэчлэх хүрээнд 12 сумаас 48 иргэнийг хасуулах, 32 иргэнийг ich.mongoluv.mn бүртгэлийн программд бүртгүүлэхээр ирүүлсэн саналыг хүлээн авч Аймгийн Соёлын биет бус өвийн мэргэжлийн орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлж тайланг СӨҮТ-д хүргүүллээ.	100%
1.2.16	Баруун замын байлдааны штаб, Ардын Хатанбаатар Магсаржавын Бунхан толгойн хадгалалт хамгаалалтын байдалд үнэлгээ хийх,	ОНТ-117.0 сая төгрөг УТ-9.9 сая төгрөг	Боловсруулсан ерөнхий төлөвлөгөөний төсөл	Хийгдэж байгаагүй	Хадгалалт хамгаалалтын байдалд үнэлгээ хийлгэж, хамгаалах хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний	Соёлын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэгт Баруун замын байлдааны штаб музей, Хатанбаатар Магсаржавын Дуулгат бунханы үйл ажиллагааг танилцуулж хадгалалт хамгаалалт, үзмэр дэглэлт сайжруулах саналыг уламжилж, үүнийг дагуу хөрөнгө оруулалт, үзмэр дэглэлт хийгдэхээр	100%

	хамгаалах, хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг гаргаж үзмэр дэглэлтийг хийх				төслийг боловсруулна.	төлөвлөгдсөн. Баруун замын байлдааны штаб музейн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 117.0 сая төгрөгний их засвар /дээвэр, гадна фасад/ , Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9.9 сая төгрөгний дохиолол хамгаалалт, хөдөлгөөн, утаа мэдрэгч, гадна, дотор камерийг бүрэн шинэчилсэн.	
1.2.17	Диваажингийн сүм, Цагаан суврага, Бурхан багшийн энергийн цэцэрлэгт хүрээлэн, Ардын Хатанбаатар С.Магсаржавын бунхант цогцолбор, Баруун Замын байлдааны штаб музей зэрэг дурсгалт газарыг тохижуулж, аялалын маршрут бий болгож зохион байгуулах	ОНТ	Тохижилт хийж аялал зохион байгуулсан байх	-	Аялалыг зохион байгуулсан байна.	Булган сумын Засаг даргын Тамгын газар, Музей, Соёлын ордонтой хамтран Булган суманд байрлах түүхэн дурсгалт газруудын маршрутыг гарган цахимд байршуулж сурталчлан ЕБС-ийн сурагчдын дунд 2 удаагийн явган аялал өртөөчилсөн тэмцээн уралдаан зохион байгуулж 120 орчим хүүхэд хамрагдлаа	50%
1.2.18	Түүх, соёлын хөдлөх дурсгалын тооллогыг зохион байгуулах	УТ ОНТ	Тооллогод хамрагдсан дурсгалын тоо	-	Тооллог хийгдэж тайланг хүргүүлсэн байна.	Соёлын сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ний өдрийн А/317 дугаар тушаалын дагуу 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд Түүх соёлын хөдлөх дурсгалын тооллого хийх шийдвэр гарсан. Тус тооллогод Булган аймгийн 15 сумын 16 Орон нутаг судлах музей хамрагдана. Дээрх ажлын хүрээнд Музейн үзмэр, эд өлгийн зүйлийг ерөнхий бүртгэлийн дэвтэрт бүртгэж Register программд бүрэн оруулж дуусгах, сан хөмрөгөөс хасах шийдвэр гаргасан дурсгалын мэдээллийг бэлтгэх, давхардсан бүртгэлийн алдааг залруулах саналыг нотлох баримт бичиг бэлтгэх ажлыг зохион байгууллаа.	100%
1.2.19	Цогт хунтайжийн цагаан балгас, Чин толгой, Хар бухын балгас, Шивээт улааны цогцолбор, Бий булгийн балгас	УТ-12.0 сая төгрөг	Дурсгалыг хамгаалж сурталчилсан байх		Дурсгалыг хамгаалж аялалын маршрутыг бий болгож сурталчилсан байна.	Хар бухын балгасыг хашаажуулах 334.038 сая төгрөгийн төслийн зардлын тооцоог гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн. Монголын үндэсний Олон нийтийн телевизтэй хамтран “Шивээт улааны цогцолбор” дурсгалт газрын контентийг бэлтгэн олон нийтэд	

зэрэг дурсгалт газруудыг хамгаалах, түүх соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх					<p>хүргэсэн. "Монголын баялаг-330" төсөл хөтөлбөрийн хүрээнд Цогт хунтайжийн цагаан байшин, Чин толгойн балгас, Хар бухын балгас, Шивээт улааны цогцолбор, Бий булгийн балгас зэрэг дурсгалт газруудын талаар МҮОНТ-ээр мэдээлэл хүргэлээ. Цогтын цагаан байшин" дурсгалыг сэргээн засварлаж, сурталчлан таниулах зорилгоор улсын төсвийн 12.0 сая төгрөгийн санхүүжилтээр шилэн хорго бүхий үзүүлэн бий болгосон. Тус түүх дурсгалын газартай Соёлын дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг танилцан, 25 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн баг ажиллаж, аялал жуулчлалын маршрут бий болгон, "Сэтгэшгүй чандмань" яруу найргийн уралдааныг "Цогтын цагаан байшин" түүх соёлын дурсгалт газарт зохион байгуулж, 4 аймгийн 16 яруу найрагч оролцсон. Технологиор дамжуулан залууст монгол орны түүх, өв соёлыг сонирхолтой хэлбэрээр таниулах, Цогт хунтайжийн Монгол нутаг дахь түүх, бичиг соёлын дурсгалыг виртуал технологи ашиглан сурталчлах хамтарсан төслийн хүрээнд Гарааны дижитал солюшнс" ХХК, Цогт тайжийн өргөө орд сан хамтран Цогт хунтайжийн цагаан байшинг виртуал орчинд сэргээн урлаж "Виртуал орчинд сүндэрлэх Цогтын цагаан байшин" эвент арга хэмжээг зохион байгууллаа.Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчлан таниулах ажлуудыг зохион байгуулж, "Цогтын цагаан байшин", "Хар бухын балгас" түүх дурсгалын газруудыг гадаад, дотоодын 453 жуулчин ирж, үзэж сонирхлоо.</p>	100%
1.3.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ						

1.3.1	“Хос бичигтэн байгууллага-2025” болох бэлтгэл ажлыг нэмэгдүүлэх	-	Соёлын салбарын албан хаагчдын гарааны судалгааны дүн, ахицын хувь	-	Хагас жилд: Аймгийн Соёлын салбарын нийт албан хаагчдын үндэсний бичгийн гарааны түвшинг тодорхойлж сургалтад хамруулах Бүтэн жилд: судалгааны түвшинг 10 хувиар ахиулна.	Хос бичигтэн байгууллага-2025 бэлтгэл ажлыг нэмэгдүүлэх хүрээнд Соёлын салбарын 163 ажилтны Үндэсний бичгийн мэдлэгийн гарааны түвшинг тодорхойлж 109 ажилтан анхан шатны 52 ажилтан дунд шатны сургалтад хамрагдлаа.. Жилийн эцсийн байдлаар Насан туршийн боловсролын төв, Ахмад багш нарын холбоо, Ерөнхий боловсролын сургуулийн багш нартай хамтран сургалт, уралдаан, тэмцээн зэрэг 24 арга хэмжээ зохион байгуулж хос бичигтэн байгууллага-25 бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.	100%
1.3.2	“Соёлын төв, соёлын ордны орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” стандартын шаардлага хангасан номын сан, соёлын төв, соёлын ордны тоог нэмэгдүүлэх		Стандартын шаардлага хангасан соёлын төвийн тоо	-	Соёлын төв, соёлын ордны орчны стандартын шаардлага хангасан 1 соёлын төвтэй болсон байна.	Рашаант, Хутаг-Өндөр, сумын соёлын төвд 683 сая төгрөгийн их засвар, техник хэрэгслийн шинэчлэл хийгдэж шинээр батлагдсан Соёлын төв, соёлын ордны орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” стандарт хангасан 2 соёлын төвтэй болж иргэд, хүүхэд залууст хүргэх соёлын үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх бодит нөхцөл бүрдэж байна.	100%
1.3.3	Улирал бүр тодорхой сэдвийн хүрээнд гэр бүлд чиглэсэн музейн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ОНТ	Үзэсгэлэнгийн тоо, үзэгчдийн тоо	12 боловсролын хөтөлбөрөөр 2037 иргэн хамрагдсан	Жилд 4-өөс доошгүй хөтөлбөрийн дагуу үзэсгэлэн гаргасан байна.	2023 онд нийт 5 хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжүүлсэн. Үүнд: “Баруун замын байлдаан”, Бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд сумын сургагч багш бэлтгэх сургалтад "Музейн боловсрол" сэдэвт хөтөлбөр, “Монгол үндэсний уламжлалт уяа зангилаа”, “Алтаргана”, “Монгол гэрийн үүсэл хөгжил, нүүдэллэх ёс” зэрэг боловсролын хөтөлбөрүүдэд Хутаг-Өндөр сумын ЕБС, Булган сумын 1, 2, 3-р сургуулийн 218 сурагч хамрагдсан. Гэр бүлд чиглэсэн “Монгол үндэсний уламжлалт уяа, зангилаа” сэдэвт боловсролын хөтөлбөрт 10 гэр бүлийн 40 иргэн хамрагдсан.	100%
1.3.4	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, Хуулийн байгууллагатай хамтран зэрэг	ОНТ-1.5 сая төгрөг	Контентийн тоо	2 контент бэлтгэн хүргэсэн.	Аймгийн Соёлын байгууллагууд хамтран жилд 2-оос доошгүй контент бэлтгэн	Орон нутгийн Сайхан Монгол телевизтэй хамтран “Монгол бахархал” ардын язгуур урлагийг сурталчлах контент, “Тунамал туурвил” хөрөг нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэлээ. Гэр бүл хүүхэд залуучуудын	100%

	хандлага төлөвшүүлэх контент бэлтгэж түгээх				олон нийтэд хүргэнэ.	хөгжлийн газартай хамтран "Гэрэл асаая" контент, Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран "Мэргэжилдээ хайртай" 2 контентийг тус тус бэлтгэж олон нийтэд хүргэлээ.	
1.3.5	Виртуал музейг албан байгууллага, сумдад сурталчлан танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулах		Үйлчлүүлсэн хүний тоо	Виртуал 4ш тоног төхөөрөмжтэй болсон	Виртуал музейн үйл ажиллагааг сумдад зохион байгуулсан байна.	Аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгал, байгалийн үзэсгэлэнт газрууд, Монголын нууц товчоонд дурдагдсан газар орон нутаг, түүхэн үзмэрүүд болон бусад 20 гаруй нэр төрлийн контентийг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан виртуал ертөнцөд бүтээж, орон зай цаг хугацаанаас үл хамааран түүх соёлоо таниулах, сурталчлах, байнгын үзүүлгээс сэлгэн амрааж, насжилтыг уртасгах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Виртуал музейн үйлчилгээг 12 төрийн байгууллага, Булган сумын баяр наадам, Эх үрсийн баяр, Айрагны баяр, Соёлын сэргэлт(16 сум 1 тосгон) аяны хүрээнд 3714 иргэд, хүүхэд залууст хүргэж түүх соёлын өргөн мэдлэгийг олголоо.	100%
1.3.6	"Бүтээлч уншлага" аян зохион байгуулах	УТ-4.0 сая төгрөг	Төлөвлөгөөний хэрэгжилт	Булган сумын 13 ангийн 360 сурагчийг уншлагад хамруулсан	16 сум 1 тосгоны Соёлын төв төлөвлөгөө гаргаж зохион байгуулсан байна.	Аймгийн хэмжээнд Бүтээлч уншлага жилийн аян зарлаж төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж 16 сум 1 тосгоны ЕБС-ийн 164 бүлгийн 3550 хүүхэд хамрагдлаа. /АТНС 3 сургуулийн 16 бүлгийн 498 хүүхдийг 313 удаагийн ангийн уншлагад, сум сургуулийн номын сангууд 148 бүлгийн 3052 хүүхдийг ангийн уншлагад хамруулсан/ Аяны хүрээнд номын санч бүр 2-5 ангийг сонгон авч тухайн ангийн сурагчдыг жилийн эхэнд болон явцад нь номын уншлагын хурдны сорил, цээж бичгийн сорил, номын тэмдэглэл хөтлүүлэх, хуулан бичиг хийлгэж, номтой нөхөрлүүлэх соёл олон нийтийн ажил зохион байгууллаа.	100%
1.3.7	Нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх гэр бүл, хүүхэд, залуучуудад чиглэсэн соёлын боловсрол олгох олон талт ажлыг зохион байгуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо	-	Гэр бүл хүүхэд залуучуудад соёлын боловсрол олгох зорилгоор жилд 2-оос доошгүй сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна	Нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх, иргэдийн соёлын боловсролын мэдлэгийг сайжруулах зорилгоор "Хамтаараа амьдрах соёл" аяны хүрээнд "Мэндэлье, Хүндэлье Хайрлая" уриатай постерийг цахим хуудсанд байршуулж сумдын соёлын төвүүдэд хүргүүлэн олон нийтэд уриалга хүргэж ажиллалаа. Мөн гэр бүлийн болон сургууль, олон нийтийн орчинд хүүхдийн эрх, хамгааллыг сайжруулах, хүүхдээ анхаарч	100%

						сонсох, гэр бүлийн таатай уур амьсгалыг бүрдүүлэх, бие биенээ хүндлэх, хайрлах соёлыг төлөвшүүлэх зорилгоор хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үүрэг хариуцлагыг сануулсан "Хөшиг нээгдэх бүрд хүргэх нэг үг" уриалга бичлэгийг бэлтгэж Соёлын байгууллагуудад хүргүүлэн 55 үзвэр үйлчилгээ эхлэхийн өмнө 5200 гаруй иргэнд хүргэж Бүх нийтийн Соёлын боловсрол олгох сургалтыг 11 удаа зохион байгуулж 1043 хүн хамрууллаа.	
1.3.8	"Номын баяр-2023" зохион байгуулах	УТ, ОНТ-14.4 сая төгрөг	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, Оролцогчдын тоо	Хаврын номын баярт 800, намрын номын баяр 400 гаруй хүн оролцсон.	16 сум 1 тосгон номын баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн байна. Уншлагыг дэмжих олон талт ажлыг зохион байгуулж иргэдийг өргөнөөр хамруулсан байна.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалт, "Номын баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Үндэсний бичиг, соёл, номын өдрүүдэд хавар, намрын арга хэмжээг нэгдсэн удирдамжийн дагуу 16 сум 1 тосгоны хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлээ. Тус арга хэмжээний хүрээнд Номын сангийн хууль сурталчлах, театрчилсан үлгэр, номын хэлэлцүүлэг, мэтгэлцээн, Монгол ардын оньсон болон хөлөгт тоглоом наадгай сурталчлах, шинэ ховор номын үзэсгэлэн худалдаа зэрэг- 29 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж 6300 орчим иргэд хүүхэд залуусыг хамруулж нийт 5.0 сая төгрөгийн төсөв зарцууллаа. 2023 онд 671 ширхэг, 9.4 сая төгрөгийн номоор фонд баяжилт хийсэн. Үүнээс төсвөөс худалдаагаар 571 ширхэг, 7.6 сая төгрөгийн ном, бэлэг хандиваар 100 ширхэг, 1.9 сая төгрөгийн ном, 5 нэр төрлийн 583,800 төгрөгийн тогтмол хэвлэлээр фонд баяжилт хийж уншлагад гаргаж байна. Өмнөх оны жилийн эцсээс номын сангаар үйлчлүүлэгчийн тоо 3 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100%
1.3.9	Соёлын үнэт зүйлсийг судлан соёлын орчин орон зай брэндийг бий болгох чиглэлээр дэмжлэг үзүүлэх	-	Соёлын брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг эдийн засгийн эргэлтэнд оруулсан байх	-	Соёлын нөөц орон зайд тулгуурласан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр	1.1.1 дэх заалттай давхардсан	

					тодорхой арга хэмжээ авсан байх		
1.3.10	Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	-	Хагас жилд: Аймгийн Соёл урлагийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын угийн бичиг хөтлөлтийн судалгааг гаргасан байх Бүтэн жилд: Судалгааны үр дүнг 10% ахиулна	Соёлын салбарын 158 ажилтнаас судалгаа авч нэгтгэсэн. Үүнээс 38 буюу 24% нь угийн бичиг хөтөлж байна. Аймгийн хэмжээнд сургалт нөлөөллийн 24 арга хэмжээ зохион байгуулж 718 иргэн хамрагдсан байна.	100%
1.4.Салбарын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.4.1	Соёлын салбарын хүний нөөцийг бэлтгэх	-	Дэмжлэг үзүүлсэн хүүхдийн тоо	5 оюутанд дэмжлэг үзүүлсэн.	5 оюутанд дэмжлэг үзүүлсэн байна.	Энэ онд аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн тэтгэлгээр Соёл урлагийн их сургуульд 5, Сити их сургуульд 1 оюутан элсэн суралцаж Соёл урлагийн чиглэлээр суралцаж буй 10 оюутанд нийт орон нутгийн төсвийн 35.5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн.	100%
1.4.2	Соёлын салбарт ажиллаж байгаа мэргэжлийн бус ажиллагсдыг мэргэжлийн болгоход дэмжлэг үзүүлэх	-	Мэргэжил эзэмшсэн хүний тоо	-	Жилд 2-с доошгүй хүнийг сургасан байна.	Аймгийн соёл урлагийн салбарт ажиллаж байгаа 174 ажилтнаас 65.5 хувь буюу 114 нь мэргэжлийн ажилтан байна. Соёлын байгууллагуудад ажиллаж буй мэргэжлийн бус 61 ажилтнаас 8 ажилтныг СУИС-д эчнээгээр сурахад дэмжлэг үзүүлсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар соёлын салбарын мэргэжилтэй боловсон хүчний нөөц 58.0 хувьтай байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар мэргэжлийн хүний нөөцийн хангалт 65.5 хувь болж, өмнөх оноос 7.5 пунктээр нэмэгдсэн байна.	100%

1.4.3	Олон улсын болон улс, бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдах уралдаан тэмцээнд театр, мэргэжлийн уран бүтээлчид, хүүхэд залуучуудыг оролцуулахад бүх талын дэмжлэг үзүүлж өргөнөөр хамруулах	ОНТ-13.0 сая төгрөг	Дэмжлэг үзүүлсэн уран бүтээлч, хүүхэд багачуудын тоо	4 уран бүтээлч, 1 сурагчдын хамтлагт дэмжлэг үзүүлсэн.	Жилд 5-аас доошгүй уран бүтээлч, хүүхэд багачуудыг дэмжсэн байна.	Үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг “Орших уу эс орших уу” шоунд оролцсон ХЖТ-ын 1 уран бүтээлч, Соёлын ордны дэргэдэх уран нугаралт амьд хөгжмийн “Алухай” хамтлагт нийт 4.5 сая төгрөгийн, “Хүн домог” үндэсний бүжгийн уралдаанд оролцсон Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн дэргэдэх Язгуур-1 хамтлагт 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Улсын чанартай дуулаачдын 5 уралдаанд ХЖТ-ын 6 уран бүтээлч оролцож тус уран бүтээлчдэд цалинтай чөлөө олгож Олон Улсын уралдаанд оролцох эрх авсан 2 уран бүтээлчид орон нутгийн төсвөөс 7.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Мөн БНСУ-д зохион байгуулагдсан МАМФ Олон улсын соёлын фестивальд Хөгжимт жүжгийн театрын 4 уран бүтээлч, Хутаг-Өндөр сумын Язгуур-2 хамтлагийг дэмжин оролцуулсан.	100%
1.4.4	Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах, сургалтад хамруулах	Төсөв	Хамрагдсан хүний тоо, Зохион байгуулсан сургалтын тоо	Соёлын яам, Соёл Урлагийн Их сургуулиас зохион байгуулсан 5 багц сургалт, Соёл урлагийн газраас зохион байгуулсан 8 чиглэлийн сургалт, Соёлын яам, Соёлын өвийн Үндэсний төв, бусад төрийн байгууллагаас зохион байгуулсан 18 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 423 ажилтан албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.	Соёл урлагийн газар, дээд шатны байгууллагаас зохион байгуулах сургалтад хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлнэ.	Соёл урлагийн газар нь 9 удаагийн танхимын болон цахим сургалт зохион байгуулж харьяа байгууллагын 240 гаруй албан хаагчийг хамруулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Дээд шатны болон бусад төрийн байгууллагаас зохион байгуулсан 30 удаагийн сургалтад давхардсан тоогоор 357 албан хаагчийг хамруулсан. Төрийн захиргааны, ахлах түшмэлийн багц сургалтад-1, төрийн албаны чиглүүлэх сургалтад-2, Төсөв, архив албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 2 албан хаагчийг тус тус сургалтад хамруулсан.	100%

1.4.5	Соёлын салбарын албан хаагчдын дунд “Соёлын түүчээ” спортын наадам зохион байгуулах	ОНТ-3 сая төгрөг	Хамрагдсан хүний тоо,	2022 онд зохион байгуулж 20 байгууллагын 150 гаруй албан хаагчид хамрагдсан.	Спортын наадам зохион байгуулж идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр эрүүл мэндийг дэмжиж хамтын ажиллагааг сайжруулсан байна.	Соёлын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, шинэ санал санаачилга хэлэлцэх, туршлага солилцох, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Соёлын түүчээ-2023” Соёлын салбарын ажилтан, албан хаагчдын нэгдсэн уулзалт сургалт, спортын наадмыг Рашаант суманд зохион байгуулж 150 гаруй албан хаагчдыг хамрууллаа.	100%
1.4.6	Аймгийн хэмжээнд “Шилдэг соёлын ажилтан” соёлын салбарын “Хүндэт тэмдэг”-тэй болох	-	Журам батлагдсан эсэх	-	Журам боловсруулагдаж батлагдсан байна	Соёлын салбарын "Оюу мэлмий" тэргүүн шагналын журмыг боловсруулан батлуулж Yesui ХК-тай гэрээ байгуулан "Оюу мэлмий" хүндэт тэмдэг 3 ширхэг хийлгэсэн.	100%
1.4.7	Соёлын ажилтны өдрийг “Соёлын орон зай” уриан дор бүтээлчээр тэмдэглэн өнгөрүүлэх	-	Зохион байгуулсан арга хэмжээ	Соёлын бүтээлч үйлдвэрлэл-Соёлын салбар дахь төсвийн шинэчлэл хэлэлцүүлэг зохион байгуулж, Сансар-1 Сансар-2 цэцэрлэгт хүрээлэнгийн сүүдрэвч, сандал, баримал зэргийг будаж өнгө үзэмжийг сайжруулсан.	Соёлын ажилтны өдрийг “Соёлын орон зай” уриан дор бүтээлчээр тэмдэглэн өнгөрүүлсэн байна.	Соёлын ажилтны өдрийн хүрээнд Соёл урлагийн газар, Хөгжимт жүжгийн театр, Төв номын сан, Музей, 16 сум, 1 тосгоны Соёлын төвийн 140 ажилтан албан хаагчдад чиглэл бүрээр мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулсан. Төв номын сангийн ажилтнуудад болон соёлын төвийн номын санчдад Соёлын бодлого-Соёлын боловсрол сэдвээр, Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчдэд Урлагийн салбарын шинэчлэл”, Театрын соёл, сэдвээр, Соёлын төв, Музейн ажилтнуудад Төрөөс соёлын өвийн талаар баримталж буй бодлого шийдвэр, Аймаг орон нутгийн соёлын өвийн хадгалалт хамгаалалт” сэдвээр тус тус сургалт зохион байгууллаа. Соёлын салбарын үйл ажиллагааг сурталчлах, соёлын орон зайг бий болгох, Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Соёлын сэргэлт 2023” аяны үйл ажиллагааг аймгийн 16 сум 1 тосгоны хэмжээнд зохион байгуулж нийт 12530 хүүхэд 2000 орчим иргэд оролцож соёлын олон талт хөтөлбөрт хамрагдлаа. Соёлын сэргэлт аян нь хөдөөгийн ард иргэд, хүүхэд багачуудад соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, салбарын ажилтан албан хаагчдын ур чадварыг дээшлүүлж, төрийн бодлого шийдвэр, хууль	100%

						тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, тухайн нутаг дэвсгэрийн онцлог, соёлыг олон нийтэд сурталчилсан, улсын хэмжээнд Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн үзүүлэлтийг нэмэгдүүлсэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.	
1.4.8	Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвих /франчайзинг нэвтрүүлэх/	УТ-3.0 сая төгрөг, ОНТ-1.3 сая төгрөг	Уран бүтээлийн тоо, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь	Жилд шинээр 1 уран бүтээл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь 21 %.	Жилд 2-с доошгүй хүүхдэд зориулсан уран бүтээл туурвиж, үйлчлүүлэгчдээс хүүхдийн эзлэх хувийг 10 хувиар нэмэгдүүлнэ. Монгол Улсын хүүхэлдэйн театртэй франчайзингийн гэрээ байгуулан 1 уран бүтээл туурвисан байна.	Г.Сэлэнгээгийн зохиол "Бахархалт ойн амьтад" хүүхдийн жүжгийг тайзнаа тавьж 500 гаруй хүүхдэд хүргэсэн. Монгол Улсын хүүхэлдэйн театртэй франчайзингийн гэрээ байгуулж Ж.Дашдондогийн зохиол "Алтан хөрш" хүүхдийн жүжгийг тайзнаа тавьж аймгийн төв болон 10 сумын 2293 хүүхэд багачуудад хүргэж соёлын боловсрол олголоо.	100%
1.4.9	Салбарын олон нийтийн түншлэлийг өргөжүүлж, олон талт арга хэмжээг эрчимжүүлнэ.	ОНТ-3.5 сая төгрөг	Хамтран ажилласан байгууллагын тоо,	-	Тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг ТББ, холбоодтой хамтран ажилласан байна.	"Булган хангай" ардын урлаг өв соёлын наадмын Соёлын бүтээлч үйлдвэрлэл, урлалын уралдааныг Монголын урчуудын эвлэлийн салбар хороотой, Уран-Өд яруу найргийн наадмыг Монголын зохиолчдын эвлэлийн Булган аймаг дахь салбартай, Хангинахуйн шагайн тойром"-г Монголын шагайн харвааны холбоо болон аймгийн шагайн харвааны холбоотой хамтран зохион байгуулж, МСНЭ-ийн салбар хороотой "Тунамал туурвил" хөрөг нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэлээ. 8 сумын Соёлын төв, ахмадын холбоо, ахмад багш нарын холбоо, эмэгтэйчүүдийн холбоо, уяачдын холбоо болон зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран 10 төрлийн үйл ажиллагааг зохион байгууллаа.	100%
1.4.10	Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага урын сангийн бодлогоо тодорхойлох	-	Урын сангийн бодлого тодорхойлогдсон байх	-	Урын сангийн бодлогоо тодорхойлсон байна.	Булган аймгийн ИТХ-ын ээлжит XIV хуралдааны шийдвэрээр ХЖТ-ийг Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн Төрийн соёрхолт Н.Наранбаатарын нэрэмжит болгож тогтоолыг гардуулан өгсөн. Тис ажлын хүрээнд нэрэмжит болсны нээлтийн арга хэмжээг 10 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд	30%

						Булган аймагт зохион байгуулж Улсын драмын эрдмийн театр, Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын жүжигчдийн хамтарсан Оросын алдарт зохиолч Б.Карасногоровын “Би ч гэсэн жаргамаар байна” драмын жүжгийг тайзнаа тавьж үзэгчдийн хүртээл болгосон.	
1.4.11	Орон нутгийн онцлог бүхий уран бүтээл туурвин, алслагдсан сумын иргэд, хүүхэд, залуучуудад хүргэх	УТ-4.0 сая төгрөг, ивээн тэтгэлэг-2.5 сая төгрөг	Уран бүтээлийн тоо, Төлбөртэй үзвэрийн үзэгчийн тоо	Төлбөртэй үзвэрийн үзэгч 4570	Жилд 1-с доошгүй уран бүтээл туурвин, төлбөртэй үйлчлүүлэгчдийн тоог 5 хувиар нэмэгдүүлсэн байх	Үйзэн хээр дан хөгжмийн уран бүтээл шинээр туурвиж үзэгчдийн хүртээл болгосон. УДЭТ болон Булган аймгийн ХЖТ-ийн хамтын ажиллагааны хүрээнд Оросын алдарт зохиолч В. Красногоровын бүтээл, Төрийн соёрхолт, МУУГЗ Н.Наранбаатарын найруулга “Би ч гэсэн жаргамаар байна” уянгын драмын жүжгийг тайзнаа тавьж аймгийн төв 10 сумын 1255 үзэгчдэд хүргэж Тэшиг, Хангал, Баян-Агт, Хутаг-Өндөр сумдад ХЖТ-ын бүрэлдэхүүн “Хүрч үйлчилье” аяны хүрээнд 1000 гаруй иргэдэд соёл урлагийн үйлчилгээг хүргэлээ. Төлбөртэй үйлчлүүлэгчдийн тоо 7253 буюу 6 хувиар өссөн байна.	100%
1.4.12	Урлаг уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлэх, үндэсний агуулгатай контентийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	УТ-1.0 сая төгрөг	Контентийн тоо	-	Жилд 3-аас доошгүй арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Орон нутгийн Сайхан Монгол телевизтэй хамтран Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан “Монгол бахархал” ардын язгуур урлагийн тоглолт, “Дэлхийн Алтаргана-ХV” наадам, Буриад зон, өв соёл аяны хүрээнд зохион байгуулсан Буриад дуу бүжгийн уралдаан, Булган хангай ардын өв соёлын наадмыг тус тус олон нийтэд хүргэлээ. Мөн “Мянган уулын цэцэг” жүжгийн дуу “Хэнээс ч нуугаагүй хайр”, “Ай сайхан Навчаа” “Түрүү магнай” зэрэг дууны уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлж олон нийтэд хүргэлээ.	100%
1.4.13	Кино, дуу, хөгжим, дүрслэх, дизайн, бусад тайзны урлагийн төрлийг хамруулсан уралдаан, тэмцээн арга хэмжээ зохион байгуулах	ОНТ-20.3 сая төгрөг, УТ-19.2 сая төгрөг	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Чиглэл бүрээр 2-оос доошгүй арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Дуу, хөгжим, бүжиг, загвар дизайн, гэрэл зургийг төрлийг хамруулсан аймгийн хэмжээний уралдаан-7, сум орон нутгийн хэмжээний уралдаан-20, тэмдэглэлт баяр ёслолыг тохиолдуулан театр, соёлын төвүүд-20 тоглолт, бусад үзвэр үйлчилгээ-93 зохион байгуулж нийт 24117 хүнд хүргэн Театр, Соёлын төв, ордны дэргэдэх 9 төрлийн дугуйланд давхардсан тоогоор 1564 хүүхэд хамрагдсан өмнөх оны хагас жилээс зохион байгуулсан үйл ажиллагааны тоо 8 хувиар үйл	100%

						ажиллагаанд оролцогчдын тоо 5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
1.4.14	Аймаг, сумын баяр наадмын Соёл урлагийн арга хэмжээг нэгдсэн өнгө төрх агуулгад нийцүүлэн зохион байгуулах	-	Хэрэгжилтийн тайлан	Жил бүр зохион байгуулдаг.	Нэгдсэн өнгө төрх агуулгад нийцүүлэн зохион байгуулсан байна.	Аймгийн баяр наадмын нээлт, хүндэтгэлийн тоглолтын арга хэмжээг Аялал жуулчлал, " Их Алтаргана"-2024 үйл ажиллагааны агуулгыг шингээн нэгдсэн өнгө төрх агуулгаар зохион байгууллаа.	100%
1.4.15	Гадаад, дотоодын шинээр кино бүтээхэд шаардагдах, дэд бүтцийн/ зам, харилцаа холбоо, цэвэр ус, зочид буудал, амралтын газар гэх мэт/ судалгаа, кино зураг авах байгаль газар зүйн онцгой байршлын жагсаалтыг гаргаж, мэдээллийн сан үүсгэх	-	Мэдээллийн сан бий болсон эсэх	-	Судалгаа жагсаалт бүхий мэдээллийн сан үүссэн байна.	Кино зураг авах, байгаль газар зүйн онцгой байршлын жагсаалтыг гаргаж, mnfilmcouncil@gmail.com хаягаар Кино урлагийн зөвлөлд хүргүүлсэн. Соёлын аялал жуулчлалын дүр төрх, онцлог нөөцийг тодорхойлох судалгааг 5 сумаас авч Соёлын яаманд хүргүүлсэн.	100%
1.4.16	"Булган хангай" урлагийн наадам зохион байгуулах	ОНТ -9.5 сая төгрөг	Оролцогчдын тоо	2017, 2019, 2021 онд урлагийн наадмыг зохион байгуулсан	"Булган хангай" урлагийн наадам зохион байгуулна.	Аймгийн Засаг даргын Шинэ хөгжлийн зам үйл ажиллагааны хөтөлбөр, төрөөс соёл урлагийн талаар баримталж буй бодлогын хэрэгжилтийг хангах, ардын урлаг соёл, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх өвлүүлэн уламжлуулах зорилгын хүрээнд орон нутгийн төсвийн 9.5 сая төгрөгөөр "Булган хангай" ардын урлаг өв соёлын наадмыг Хөгжимт жүжгийн театр, Монголын урчуудын эвлэлийн Булган аймаг дахь салбар хороотой хамтран зохион байгууллаа. Тус уралдаанд Булган аймгийн 12 сум 1 тосгоны 100 гаруй авьяастнууд 12 төрлөөр оролцож багийн дүнгээр Булган, Хялганат тосгон, Орхон сумд тэргүүлээ. Энэхүү арга хэмжээний онцлог нь соёлын бүтээлч үйлдвэрлэл, урлалын төрлийг уралдаанд оруулсан нь бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид, урчуудыг дэмжиж идэвхжүүлсэн онцлогтой байлаа.	100%

1.4.17	Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо	-	Байгууллага тус бүр 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн соёлын байгууллагууд Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн 230 иргэнд нүүдлийн номын сангийн үйлчилгээ, виртуал музей, урлагийн тоглолт зэрэг соёлын үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэлээ. Булган сумын Соёлын ордон тоглолтын тасалбарын орлого болон бусад хандив тусламжаар зорилтот бүлгийн өрх толгойлсон 1 эмэгтэйг гэртэй болгож улирал бүр хүнсний зүйл, баяр ёслолоор гарын бэлэг өгч ажиллаж байна. Скаут бүлгийн сурагчид хандивын аян зохион байгуулж зорилтот бүлгийн 38 хүүхдэд гарын бэлэг түгээж амьд хөгжмийн тоглолт зохион байгууллаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах сарын ажлын нээлтэд урлагийн тоглолтоор үйлчилж Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүтээлийн үзэсгэлэн гаргаж нийтэд сурталчиллаа.	100%
1.4.18	Өвлөн уламжлагчдын тайлбарт тоглолтыг иргэдэд зохион байгуулах	-	Үзэгчдийн тоо	2022 онд Өвлөн уламжлагчдыг алдаршуулах тайлбарт тоглолт зохион байгуулж 300 гаруй хүүхэд үзсэн.	Өвлөн уламжлагчдын тайлбарт тоглолтыг иргэдэд зохион байгуулна.	Өв соёлоо эрхэмлэн дээдлэх, хайрлан хамгаалах, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, зорилгоор бөхчүүд, уяачид, морь цоллоочид, шагай, сур харваачдын төлөөлөл 10 хүн оролцсон “Монгол наадам” сэдэвт тайлбарт тоглолтыг зохион байгууллаа. Тоглолтод оролцсон өвлөн уламжлагчдын холбогдох эд өлгийн зүйлээр үзэсгэлэн гаргаж иргэдэд хүргэлээ. Мөн Хөөмий, морин хуур, уртын дуу, бий биелгээний өвлөн уламжлагчид Булган сумын 1, 2,3 дугаар сургуулийн 317 хүүхдэд тайлбарт тоглолт зохион байгуулсан.	100%
1.4.19	Шилдэг 100 хүүхдийн тоглолт зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	-	Шилдэг 100 хүүхдийн тоглолт зохион байгуулсан байна.	Улс аймгийн чанартай уралдаан тэмцээнд оролцож амжилт гаргасан Булган хангайн авъяаслаг хүүхдүүдийг алдаршуулах, урамшуулах, сурталчлан таниулах зорилгоор “Булган хангайн хүүхдүүд” шилдэг 100 хүүхдийн тоглолтыг Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулж тус тоглолтод 14 сумын авъяаслаг хүүхдүүд оролцлоо. 2006, 2008 онуудад шилдэг 50 хүүхдийн тоглолт зохион байгуулж байсан бол энэ жилийн хувьд хамрах хүрээг өргөжүүлэн 100 хүүхдийн	100%

						тоглолт зохион байгуулж буйгаараа онцлог арга хэмжээ боллоо.	
Хоёр.Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
2.1.1							
2.1.2							
Гурав.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
3.1	Соёлын салбарын ажилтан албан хаагчдыг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний сургалтанд хамруулах бусад салбарын хуулийн мэдлэг олгох	-	Жилд 2-оос доошгүй удаа 100 хувь сургалтанд хамруулсан байх	2022 хуулийн мэдлэг олгох 1 сургалт, салбарын чиглэлээр 4 сургалтанд 100 хувь хамруулсан	Ёс зүйн болон харилцаа хандлагыг сайжруулах сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.	Соёлын салбарын 85 албан хаагчийг Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академаас зохион байгуулсан ёс зүйн сургалтад хамруулсан. Эерэг хандлага аз жаргалтай амьдрал" сэдэвт сертификаттай сургалтад бүх албан хаагчдаа хамруулсан. Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтад байгууллагын бүх ажиллагсад болон аймгийн төвийн соёл, урлагийн байгууллагуудын ажилтнуудыг хамрууллаа. Төсвийн тухай хууль, Оюуны өмч, Зохиогчийн эрхийн тухай хуулиар соёлын байгууллагын удирдлагууд, байгууллагын 6 ажилтанд Авлигын тухай болон Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт зохион байгуулсан.	100%
3.2	Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагаа хэрэгжүүлэх		Хэрэгжилтийн хувь	-	Хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	Нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд 15 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг 90% ханган ажиллалаа. Албан хаагчдыг шаардлагатай техник тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, интернэт дотоод сүлжээгээр хангаж, дээд шатны болон холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан 21 удаагийн сургалтад хамрууллаа. Ажилласан жилийн урамшуулал-5, хүүхэд асрах чөлөө-1, түлээ нүүрсний хөнгөлөлт-2 бие бялдарын сорилд-7 албан хаагчийг тус тус хамруулж тэмдэглэлт өдрийг тохиолдуулан албан хаагчдын 10 хүүхдэд гарын бэлэг өгсөн.	100%
Дөрөв.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
4.1	Музейн сан хөмрөгийн бүртгэлийг шинэчлэл хийх	ОНТ	Шинэчилсэн тооллогын дүн	5052 үзмэр бүртгэлтэй.	Тооллогын үйл ажиллагаа хийгдэж бүртгэлийн сан	2023 онд 49 дэсийн 82 ширхэг үзмэр шинээр бүртгэн музейн үзмэрийн 1.6 хувьтай тэнцэхүйц үзмэрээр сан хөмрөгийг баяжуулсан.	100%

					шинэчлэгдсэн байна.		
4.2	Мэргэжлийн урлагийн байгууллагын урын сан, уран бүтээлчдийн мэдээллийг цахимд байршуулах	-	Хэрэгжилт	-	Соёл урлагийн газрын вэб сайтад тусгай цэс үүсгэж байршуулсан байна.	Урын сан, сан хөмрөгийн мэдээллийг нэгтгэн Соёлын яаманд хүргүүлж цахим хуудсанд цэс үүсгэж байршууллаа.	100%
4.3	Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувийг нэмэгдүүлэх	-	Нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	Цахим сан хөмрөгийн эзлэх хувь 0.49	Цахим сан хөмрөгийн эзлэх хувийг 1%-д хүргэнэ.	Цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэхэд анхаарч 70 ширхэг аудио ном, орон нутгийн 314 нүүр тогтмол хэвлэл, Монгол бичгийн дөт зам, Шинэ олдсон тамга, Володя Ульянов, Чойжид дагинын тууж, Хуучин хүү, Алтан хүүхэд, Багын найз, Ерөөл, Номын ном, Малчны уламжлалт ёс гэсэн 10 номыг цахим хувилбарт оруулсан.	100%
4.4	Соёл урлагийн үйлчилгээнд баримтлах стандарт болон шинээр батлагдсан “Соёлын төв ордны орчин, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 6981:2022 стандартын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх	-	Хэрэгжилтийн тайлан	-	Улсын үзлэг хяналтыг аймгийн хэмжээнд зохион байгуулж үр дүнг тайлагнасан байна.	Монгол Улсын Соёлын яамны 2023 оны 4 дүгээр сарын 11-ний 3/879 дугаар албан бичгээр ирүүлсэн эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу 16 сум, 1 тосгоны Соёлын төвд Музейн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлт, Урлагийн тоглолтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлт, Номын сангийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж шилэн хяналтын цахим системд бүртгэж тайланг Соёлын яамны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн.	100%
Тав.Хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
5.1.Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.1.1	Цахим шилжилт, цахим засаглалыг нэвтрүүлэхэд шуурхай удирдлагаар хангах, эрхлэн гүйцэтгэх	-	Тоон гарын үсэг хэрэглэгчдийн тоо	Аймгийн хэмжээнд Соёлын салбарын 85 албан хаагч тоон гарын үсэгтэй.	Тоон гарын үсэг хэрэглэгчдийн тоог 150-д хүргэх.	Соёл урлагийн газар болон харьяа байгууллагын нийт 147 албан хаагч буюу 84% нь тоон гарын үсэгтэй болсон.	100%
5.1.2	Вэб сайтын цэс, мэдээллийг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн дагуу боловсруулж оруулах	-	Сайтаа шинэчлэсэн эсэх	2022 онд Вэб сайттай болсон.	Вэб сайтыг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн дагуу засварлаж,	Соёлын яамнаас зохион байгуулж буй олон нийтийг соён гэгээрүүлэх, үндэсний бахархал, өв соёлыг таниулах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд мэдээллийн технологийг нэвтрүүлэх цахим шилжилтийн ажлын хүрээнд Байгууллагын Вэб сайтыг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай	

					мэдээллийг оруулсан байна	хууль"-ийн 8 дугаар зүйлийн дагуу бүтэц зохион байгуулалтыг хөгжүүлж нийт 72 мэдээллийг байршуулан шаардлагтай мэдээллийг тухай бүр шинэчилж байна. Мөн Шил ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор цахим хуудасны үнэлгээг 7 хоног бүр хийж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.	100%
5.1.3	Бүх албан хаагчид албаны цахим хаягтай болж, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах	-	Албаны цахим хаяг хэрэглэгч ТАХ-ын тоо	Албаны цахим хаягийг албан үйл ажиллагаанд хэрэглэж хэвшээгүй.	Албан хаагчид албаны цахим хаягийг хэрэглэж хэвшсэн байна	Mail.gov.mn /Төрийн цахим шуудан/ хаягийн байгууллагын удирдлагын эрхийг үүсгэж нийт 9 албан хаагч албан хэрэгцээндээ mail.gov.mn хаягаа ашиглаж байна. ERP-/Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем/-д Байгууллага, хэлтэс, албан хаагч нарын бүртгэлийг үүсгэн ашиглаж байна.	100%
5.1.4	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, хэрэгжилтийг улирал тутам тайлагнах	-	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэлтийн хувь	2022 оны жилийн эцсийн байдлаар соёлын байгууллагуудад /цаасаар/ нийт 93 өргөдөл, 2 гомдол ирж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	"Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичиг, дүрэм журмыг баримтлан ажиллаж хэвшсэн байна.	Соёлын байгууллагуудын хэмжээнд ирсэн 88 өргөдөл, 7 гомдлыг судалж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Саналын хайрцаг хийж байрлуулсан.	100%
5.1.5	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг цахимжуулж, хяналт тавих	-	Өргөдөл гомдлыг цахим хэлбэрт оруулах ажлын хувь	-	Өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах нөхцөлийг хангаж ажиллах	Байгууллагын вэб сайт /bu.mos.gov.mn/-д Өргөдөл гомдол хүлээн авах цэс үүсгэж Иргэд, ААН байгууллагаас цахимаар өргөдөл, гомдол хүлээн авах боломжийг бүрдүүлсэн.	100%
5.1.6	Төрийн байгууллагын хүний нөөцийг нэмэгдүүлэх	-	Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын тоо Зохион байгуулсан арга хэмжээ	2022 оны байдлаар СУИС, МУК-ийн элсэлтийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж дээрх сургуулиудад 19	Хүний нөөцийг нэмэгдүүлэх судалгаа гаргаж төлөвлөгөөний биелэлт 30 хувьд хүргэнэ	Аймгийн соёл урлагийн салбарт эхний хагас жилийн байдлаар 163 ажилтан, албан хаагч ажиллаж байгаа бөгөөд Үүнээс төрийн захиргааны-7, төрийн үйлчилгээний- 156 ажилтан байна. "Хот хөдөөгийн сэргэлт" аяны хүрээнд Соёлын салбарын онцлог, ажиллах нөхцөл, сул орон тооны мэдээллийг оюутан залуучуудад хүргэлээ.	70%

				оюутан элсүүлж, 3 оюутанд 1 жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон.			
5.1.7	Төрийн албан хаагчдыг сургаж мэргэшүүлэн чадваржуулах		Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан болон боловсролын зэргээ ахиулсан албан хаагчдын тоо	-	Төрийн албанд анх томилогдсон болон дунд хугацааны давтан сургалт, ахлах, эрхлэсэн, архив бичиг хэргийн зэрэг нэмэгдүүлэх, мэргэшсэн нягтлан бодогч, магистр, доктор ... гэх мэт)	1.4.4 давхардсан заалт	-
5.1.8	Суманд ажиллаж байгаа эмч, багш болон бусад нарийн мэргэжлийн ажилтнуудад орон сууцны нөхцөлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх					Хамааралгүй заалт	-
5.2.Хууль, эрх зүйн хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.2.1	Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт амжилттай хамрагдах	-	Улсын үзлэгт хамрагдах	-	Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт хамрагдсан байна.	Улсын үзлэгт бэлдэх ажлын хэсгийг байгуулсан. Шалгуур үзүүлэлтээр шалгаж үзэхэд 80 хувьтай байна. Архив бичиг хэргийн ажилтныг 1 удаагийн сургалтад хамруулж аймгийн Архивын тасгаас зөвлөн туслах үйлчилгээ авсан.	90%
5.2.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, БНШК байгуулж, ажиллуулах, байгууллагын архивын баримтын тооллого хийх, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг гаргаж хэрэгжүүлэх	-	Зохион байгуулсан сургалт, хяналт шалгалтын тоо, баримт нягтлан шалгах комиссын хурал, тооллогын үр дүн	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн заавар, стандарт, байгууллагын архивын заавар, тооллогын журам шинээр батлагдсан	Хууль, заавар, дүрэм, стандартын хэрэгжилтийг 95 хувьд хүргэх	БНШК-ийг шинээр байгуулан 2 удаа хуралдан хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг гаргаад байна. Мөн байгууллагаас гарч буй тушаал шийдвэр, ирсэн, явсан баримт бичигт 1 удаа үзлэг шалгалт хийж зөвлөмж өглөө.	70%

5.2.3	“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрх зүйн сургалт сурталчилгааг дотооддоо буюу өөрийн ажилтнуудад болон гадагш чиглэсэн хэлбэрээр зохион байгуулах, аймгийн хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулагдах сургалт семинарт оролцох	-	Хөтөлбөрийн хэрэгжилтин хувь	Өмнөх онд эрх зүйн сургалт сурталчилгаа хэдэн удаа зохион байгуулсан, хэдэн хүн оролцсон нь тодорхой бус байсан	Жилдээ 2 чиглэл тус бүрээр 2-с доошгүй удаа зохион байгуулсан байх Хэдэн удаа, ямар сэдвээр, хэдэн хүн оролцсон нь тодорхой болж тайланд тусгагдсан байна.	2023 онд давхардсан тоогоор 523 албан хаагчийг сургалтад хамруулсан. Аймгийн ЗДТГ-т албан бичгээр хүсэлт гаргаж бүх нийтийн эрх зүйн боловсролын чиглэлээр 1 удаагийн сургалт авсан. Аймгийн хэмжээнд зохион байгуулсан 4 удаагийн хууль эрх зүйн сургалтад соёлын салбарын 120 гаруй албан хаагч хамрагдлаа. Төрийн албан хаагчийн ёс зүй, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, Алсын хараа 2050, хууль тогтоомжийн чиглэлээр 7 удаагийн сургалтад Соёл урлагийн газрын 8 албан хаагч, соёлын байгууллагуудын 54 ажилтан хамрагдлаа. Байгууллагын болон аймгийн төвийн соёл урлагийн байгууллагуудын ажилтнуудыг төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтад хамруулсан	100%
5.2.4	"Зөв дадал-Архигүй орчин" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллага дээрээ судалгаа гаргаж, сургалт зохион байгуулж, хяналт тавих	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	Байгууллагын хэмжээнд уг хөтөлбөрт хэрхэн хамрагдаж байгаа нь тодорхойгүй байсан	Байгууллагын хэмжээнд архидан согтуурах, явдал гаргахгүй байх	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд албан үүргээ гүйцэтгэж байх үед болон албан өрөө тасалгаанд архи согтууруулах ундааг хэрэглэхгүй байх талаар заалт тусган, нийт албан хаагчдад зөвлөмж өгч үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тус газарт архи согтууруулах ундаатай холбоотой зөрчил дутагдал гараагүй.	100%
5.2.5	Нийтийн албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулах, хадгалах, хяналт тавих, Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянуулах	-	ХАСУМ-ийг тухай бүр хянуулсан алба хаагчийн тоо, хувь	Холбогдох агентлагаас бусад агентлагийн мэдүүлэг гаргагч нарын бүртгэл судалгаагүй байсан.	ХАСХОМ болон ХАСУМ-тэй холбоотой бүртгэл судалгаатай болж, зөрчил дутагдал гаргаагүй байх.	Хөрөнгө оролгын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын судалгааг гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Төрийн албаны тусгай шалгалт өгч төрийн албанд томилогдсон хэлтсийн дарга, 2 ахлах мэргэжилтний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, 6 албан хаагч Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлж хянуулсан.	100%
5.2.6	Байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтыг сайжруулах,	-	Нэмэгдсэн гэрэлтүүлэг, камерийн тоо,	-	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд Камертай болсон байна.	ЗДТГ-ын байранд байрладаг учир 24 цагийн хамгаалалттай.	-

	зорилгоор гэрэлтүүлэг, камерын тоо байршлыг нэмэгдүүлэх						
5.3.Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.3.1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Бүх нийтээр мод бут тарих ажилд зохион байгуулалттайгаар оролцох	-	Булган сумын ЗДТГ-аас хуваарилсан тооны мод тарьж, арчлан ургуулна.	-	Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн байх	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд Булган сумын Сансар-1, Сансар-2, Сансар-3 цэцэрлэгт хүрээлэнд 62ш мод тарьж, усалгаа арчилгааг хийсэн. Байгууллагын ажиллагсад хашаандаа 6 ширхэг мод тарьсан.	100%
5.3.2	"Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аянд идэвхитэй оролцож, бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох (зам дагуу хог цэвэрлэгээний ажил, орчны 50 метрийн хог хаягдал, хог ургамал, цас мөсийг арилгах)	-	Зохион байгуулсан нийтийн цэвэрлэгээний ажилд идэвхитэй оролцоно.	-	Хотын өнгө үзэмжийг сайжруулж, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.	"Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны хүрээнд зохион байгуулсан 4 удаагийн нийтийн цэвэрлэгээнд соёл урлагийн байгууллагын 75 албан хаагч оролцсон. Байгууллагын орчны зам дагуу хог цэвэрлэгээний ажил, хог ургамал, цас мөсийг арилгах, орчны 50 метрийн хог хаягдлыг 6 удаа цэвэрлэсэн.	100%
5.3.3	Байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээнд хэмжих хэрэгсэл суурилуулах	-	Дулааны тоолуурын заалтаар төлбөр төлөх	Дулааны тоолуур байхгүй	Дулааны тоолуур суурилуулсан байна.	Хамааралгүй заалт	-
5.3.4	Эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэмнэлт гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх	-		-	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Эрчим хүчний хэмнэлттэй гэрлийг бүх өрөөнд суурилуулсан. Цайны цагаар компьютер хэрэгслээ тогтмол унтраах зөв дадлыг хэвшүүлсэн.	100%
5.4.Нийгмийн бодлогын хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ							
5.4.1	Хүн бүр эх хэл, соёлоо дээдэлж зөв бичиж хэрэглэж хэвших, байгууллага, хамт олон “Бүх нийтээрээ хос бичигтэн” болоход уриалсан нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах, сургалтанд хамрагдах	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны хэрэгжилт	Байгууллагын гадна хаяг, өрөөнүүдийн хаягийг хос бичгээр бичсэн.	Байгууллагын хаяг, цахим сайт, бичиг хэргийн хөтлөлтийг уйгаржин бичгээр бичиж хэвших, байгууллагын албан хаагчдын монгол хэл, бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Байгууллагын вэб сайтын хэлний сонголт дээр үндэсий бичгийг нэмж байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан ажиллаж байна. Албан хаагчдын Үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг тогтоон Насан туршийн боловсролын төвтэй хамтран сургалт зохион байгуулж байна. Байгууллагын албан бичгийн бүртгэлийн дэвтэрүүдийн нүүр, гадна дотор хаягжуулалтыг үндэсний бичгээр бичиж шинэчилжсэн.	100%
1.3.1 давхардсан заалт /Зорилтот түвшинг нэгтгээд 1 арга хэмжээ болгох.../							

5.4.2	Хөдөөгийн багийн иргэдэд чиглэсэн хандлагаа өөрчлөх "Хүрч үйлчилье" нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Хамрагдсан хүний тоо	-	"Хүрч үйлчилье" нөлөөллийн аяныг хэрэгжүүлсэн байх	УДЭТ болон Булган аймгийн ХЖТ-ийн хамтын ажиллагааны хүрээнд Оросын алдарт зохиолч В. Красногоровын бүтээл, Төрийн соёрхолт, МУУГЗ Н.Наранбаатарын найруулга "Би ч гэсэн жаргамаар байна" уянгын драмын жүжгийг тайзнаа тавьж аймгийн төв 10 сумын 1255 үзэгчдэд, Монгол Улсын Хүүхэлдэйн театртэй фрачайзингийн гэрээ байгуулан Алтан хөрш хүүхдийн жүжгийг тавьж аймгийн төв, 10 сумын 2293 хүүхэд багачуудад хүргэж Тэшиг, Хангал,Баян-Агт, Хутаг-Өндөр сумдад ХЖТ-ын бүрэлдэхүүн "Хүрч үйлчилье" аяны хүрээнд 1000 гаруй иргэдэд соёл урлагийн үйлчилгээг хүргэлээ..	100%
5.4.3	"Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох, сорил"-д байгууллагын албан хаагчдыг хамруулах	-	Байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулах	Нийт 10 албан хаагчийг сорил судалгаанд хамруулсан байна.	Нийт 10 албан хаагчийг сорил судалгаанд хамруулсан байна	Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох, сорил"-д 8 албан хаагчийг хамруулж зөвлөгөө авсан.	90%
5.4.4	Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулах	УТ 1.200 сая	Байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулах	Нийт 10 албан хаагчийг эрт ирүүлэгийн үзлэгт хамруулсан.	Нийт 10 албан хаагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна.	Байгууллагын 10 албан хаагчийг Орхон аймгийн "Баян-Өндөр Мед" эмнэлэгт багц шинжилгээнд хамруулж шинжилгээний төлбөрийг байгууллагын төсвөөс шийдвэрлэсэн.	100%
Зургаа.2023 онд шинээр хийж, хэрэгжүүлэх шинэлэг ажил							
6.1	"Их Алтаргана-2024" наадмын бэлтгэл ажлыг хангах	ОНТ-10.8 сая төгрөг	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо		Бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн байна.	Буриад зоны дуу хуур, бүжиг наадмыг түгээн дэлгэрүүлэх, шинэ залуу авьяастнуудыг тодруулах, бүх нийтэд соёл урлагийн боловсрол олгох зорилгоор "Буриад дуу бүжгийн уралдаан"-ыг зохион байгууллаа. Тус уралдаанд Булган аймгийн 16 сум 1 тосгоны 460 гаруй авьяастнууд 4 төрөл, 6 насны ангиллаар оролцож багийн дүнгээр Булган, Тэшиг, Хутаг-Өндөр сумд шалгарлаа. Тус уралдааны үр дүнд "Алтаргана-2024" Олон улсын наадамд аймгаа төлөөлөн оролцох авьяастнуудыг урьдчилсан байдлаар сонгон шалгарууллаа. Мөн "Буриад зон-өв соёл 2023" аяны хүрээнд "Уран сайхны гэрэл зураг"-ийн уралдааныг Улсын хэмжээнд нээлттэй зарлаж нийт 17 бүтээл ирүүлснээс шилдэг	100%

						бүтээлүүдийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллалаа. Аймгийн музей "Алтаргана" боловсролын хөтөлбөр зохион байгуулж Төв номын сан Буриад өв соёл, танин мэдэхүйн холбогдолтой 14 номоор QR кодтой танилцуулга хийж цахимд байршуулж сурталчилсан. Алтаргана 2024" наадмыг зохион байгуулах хорооны анхдугаар хуралдааныг зохион байгуулан Оросын холбооны Улсын болон аймаг, орон нутгийн 100 гаруй зочид төлөөлөгчид оролцон наадмын ерөнхий удирдамж батлах, тов тогтоох асуудлаар хэлэлцүүлэг явуулан баталлаа.	
6.2	ЮНЕСКО-ийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлсэн өвийн оршин тогтнох чадварыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, тайлан	ЮНЕСКО-д Монгол улсаас бүртгэгдсэн 17 өв бүртгэгдсэн.	Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг Монгол ардын уртын дуу Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг Монгол наадам Монгол ардын Хөөмэйн урлаг Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил –битүү амьсгаа Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл Монгол уран бичлэг Шагуйн харваа Уул овоо тахих зан үйл Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл	Аймгийн хэмжээнд морин хуур, уртын дуу, хөөмий, бий биелгээний дугуйланд 225 хүүхэд хамрагдаж байна. Мөн Орхон сумын ЕБС-ийн багш бий биелгээний өвлөн уламжлагч О.Тунгалаг, Булган сумын уртын дууны өвлөн уламжлагч Х.Мөнхбаатар, Баяннуур сумын өвлөн уламжлагч Д.Зоригт нар шавь сургалт зохион байгуулж 150 гаруй хүүхэд, залуусыг хамруулсан байна. Аймгийн хэмжээнд “Булган хангай ардын урлаг, өв соёлын наадам, “Манлайн баясгалан” хүүхдийн язгуур урлагийн наадам, “Монгол наадам тайлбарт тоглолт, Өвлөн уламжлагчдын тайлбарт тоглолт 2 удаа зохион байгуулж, "Монгол бахархал" ардын язгуур урлагийн контент бэлтгэн нийт 2000 гаруй иргэд, хүүхэд залууст хүргэлээ. Мөн ЮНЕСКО-д Монгол улсаас бүртгэгдсэн 17 өвийн өвлөн уламжлагчийн тархалтын байдлын судалгааг гаргасан. Аймгийн хэмжээнд Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг /Дашинчилэн 2, Могод 3/, Уртын дуу /Баяннуур 1, Гурванбулаг 9, Могод 3, Орхон 3, Сэлэнгэ 1, Хутаг-Өндөр 3/ , Монголын уламжлалт Хөөмэйн урлаг /Баяннуур 1, Рашаант 1, Монгол баяр наадам /Гурванбулаг 1, Монгол лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил – битүү амьсгаа” /Булган 1, Орхон 1/, Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл /Баян-Агт 1, Хишиг-Өндөр 1, Сэлэнгэ 1/, Монгол шагуйн харваа /Бугат 1, Булган 1, Дашинчилэн 3, Сэлэнгэ 15/	100%

						нийт 7 төрлийн өвийн 52 өвлөн уламжлагчийн судалгааг шинэчилсэн.	
6.3	Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор ёрөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан түүх соёлын эко аялал жуулчлалын маршрут боловсруулах, хүүхдийн нэвтрүүлэг бэлтгэх, эко аялал зохион байгуулах	ОНТ-0.5 сая төгрөг	Маршрут гаргасан байна. Нэвтрүүлэг бэлтгэсэн байх, аялалд хамрагдсан хүүхдийн тоо	-	Маршрут гаргаж, нэвтрүүлэг бэлтгэн цацаж, хүүхдүүдийг аялалд хамруулсан байна.	Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн онцлог, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг таниулах зорилгоор Хөгнө тарнын байгалийн цогцолбор газрын захиргаа болон Монголын Үндэсний Олон Нийтийн телевизтэй хамтран Рашаант сумын Хөгнө хан уул, Элсэн тасархай, Их бага хийдийн туурь, Хадат хошуу зэрэг газруудаар аяллын маршрут гаргаж хүүхдийн танин мэдэхүйн “Том ахын аялал” нэвтрүүлэг бэлтгэсэн. Тус нэвтрүүлэгт Рашаант, Булган сумын ЕБС-ийн 15 сурагч оролцлоо.	100%
6 зорилт 75 арга хэмжээ							94.1%

ТАНИЛЦСАН:

ДАРГА Г.АЛДАРМӨНХ

ХЯНАСАН:

СОЁЛ УРЛАГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.БААСАНЖАВ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ,
ЦАХИМЖИЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ЛХАГВАДАШ